Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 дугаар тушаалын
7 дугаар хавсралт

# БАГАНУУР ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН
# 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2024 оны 06 дугаар сарын 10 Багануур дүүрэг

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| ***Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт*** | | | | | | | |
| Нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын төв, орон нутгийн нэгжийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын дунд хугацааны төсвийн төсөл, төсөөлөл болон төсвийн нарийвчилсан хуваарийн санал боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих, судалгаа хийх, ирээдүйн төлөв байдал, урт хугацааны урьдчилсан тооцоолол хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, санал боловсруулах | | | | | | | |
| 1.1.1 | Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан дүрэм, журам, дээд газраас ирүүлсэн заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг зохион байгуулах | Шаард-лагагүй | Хэрэгжүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн тоо | Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой НДЕГ-аас 2023 онд ирүүлсэн 12 удаагийн зөвлөмжийн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан. | Дээд газраас ирүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж, үр дүнг тооцож ажилласан байна. | Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд эрх зүйн шинэчлэлтийг хэрэгжүүлсэн онцлог жил тохиож байна. Хуулийн шинэчилсэн найруулга, түүнтэй холбодон гарсан эрх зүйн баримт бичиг, чиглэл, зөвлөмж заавар, аргачлалыг нэг мөр хэрэгжүүлэхээр холбогдох албан хаагчдад тухай бүр мэдээлэл хүргэж, хэрэгжилтийг зохион байгуулллаа. Энэ чиглэлээр дотооддоо нийтдээ 11 удаагийн мэдээлэл солилцох үйл ажиллагааг зохион байгуулсан байна.<br>2024 оны эхний хагас жилийн | 82 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байдлаар дээд газраас ирүүлсэн 41 эрх зүйн актыг 83,6%-тай хэрэгжүүлэв. | |
| 1.1.2 | Сайн дурын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх, албан бус хөдөлмөр эрхлэгчдийг сайн дурын даатгалд шинээр хамруулах, хамралтын төлөвлөгөөг биелүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтийг тогтоосон хугацаанд хүргүүлэх | Шаард-лагагүй | Сайн дурын даатгалд шинээр хамруулсан даатгуулагч (малчин)-ийн тоо, өсөлтийн хувь, төлөвлөгөөний биелэлтийн хувь | 2023 онд нийт 1430 хүнийг сайн дурын даатгалд хамруулав. | Сайн дурын даатгуулагч албан бус хөдөлмөр эрхлэгчдийг шинээр хамруулах тоог өмнөх оноос 264 хүнээр нэмэгдүүлж, төлөвлөгөөг биелүүлсэн байна. | НДЕГ-ын даргын 2024 оны А/61 дүгээр тушаалаар 2024 оныг “Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх жил” болгон зарлаж шинээр хамруулах ажил олгогч, албан журмаар даатгуулагч, сайн дураар даатгуулагчийн тоон төлөвлөгөөг баталсан. Төлөвлөгөө ёсоор сайн дурын даатгалд шинээр 264 даатгуулагчийг хамруулахаас 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар 200 даатгуулагчийг хамруулж, төлөвлөгөөг 75,8 хувиар биелүүлээд байна. Шинээр хамруулсан сайн дурын даатгуулагчдыг төрлөөр нь ангилвал малчин 38 (172,7%), 0-3 насны хүүхдээ асарч байгаа эх 18 (48,6%), хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа эх /эцэг/ 20 (24,7%) байна. | 129,7 |
| 1.1.3 | Албан журмын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор нийгмийн даатгалд хамрагдаагүй ажил олгогч, даатгуулагчдыг шинээр хамруулах, хамралтын төлөвлөгөөг | Шаард-лагагүй | Албан журмын даатгалд шинээр хамрагдсан ажил олгогч, албан журмын даатгуулагчийн тоо, өсөлтийн хувь, төлөвлөгөөний биелэлтийн хувь | 2023 онд нийт 275 ажил олгогч, 7,253 хүнийг албан журмын даатгалд хамруулсан. Үүнээс 19 ажил олгогчийн 31 даатгуулагчийг шинээр | Ажил олгогчийн тоог 30, даатгуулагчийн тоог 195 нэмэгдүүлж, төлөвлөгөөг биелүүлсэн байна. | “Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх жил”-ийн хүрээн баталсан хамралтын төлөвлөгөөний дагуу 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар 17 ажил олгогч, 39 даатгуулагчийг шинээр хамруулсан байна. Төлөвлөгөөний биелэлт ажил олгогч 56,7 хувь, албан журмын даатгуулагч 20 хувийн гүйцэтгэлтэй байна. | 67,5 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | биелүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтийг тогтоосон хугацаанд хүргүүлэх | | | хамруулсан. | | | |
| Гүйцэтгэлийн дундаж хувь | | | | | | | 93 |
| ***Хоёр. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт*** | | | | | | | |
| Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлыг хугацаанд нь олгох, өр, авлага барагдуулах ажлыг удирдан зохион байгуулах, өмчийн харилцаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, нийгмийн даатгалын сангийн хуримтлал бий болгох, нягтлан бодох бүртгэлийн мэргэжил арга зүйгээр хангах, гүйцэтгэлийг тайлагнах | | | | | | | |
| 2.1.1. | Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын төсвийн нарийвчилсан хуваарь, сар, улирлын хуваарийг мөрдөж ажиллах | Шаард-лагагүй | Нийгмийн даатгалын сангийн 2024 оны орлого, зарлагын гүйцэтгэл | Нийгмийн даатгалын санд 2023 онд 38920,1 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардалд 45105,4 сая төгрөг зарцуулсан. | Батлагдсан төсвийн хуваарь, дээд газраас ирүүлсэн зөвлөмж, чиглэлийг мөрдөж ажилласан байна. | Нийгмийн даатгалын санд 2023 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 21339,5 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардалд 23075,2 сая төгрөг зарцуулсан. | 131 |
| 2.1.2. | Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль, НДЕГ-ын даргын баталсан нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлын төсвийн нарийвчилсан | Шаард-лагагүй | Нийгмийн даатгалын байгууллагын 2024 оны үйл ажиллагааны урсгал зардлын төсвийн гүйцэтгэл | Нийгмийн даатгалын байгууллагын 2023 оны үйл ажиллагааны урсгал зардалд 646,5 сая төгрөг зарцуулсан. | Батлагдсан төсвийн хуваарь, дээд газраас ирүүлсэн зөвлөмж, чиглэлийг мөрдөж ажилласан байна. | 2024 оны 05 дугаар сарын байдлаар батлагдсан төсвийн хуваариар 333,5 сая төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагаанд 277,4 сая төгрөгний зардал гаргасан нь нийт төсвийн 83,17 хувийг эзэлж байна. | 116,8 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хуваарь, сар, улирлын хуваарийг мөрдөж ажиллах | | | | | | |
| 2.1.3. | Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх | | Батлагдсан 27,479,707.9 төгрөгийн шимтгэлийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг сараар, өссөнөөр жигд биелүүлэн ажиллана. | Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг сар, улирал, жилээр жигд ханган биелүүлж, нийгмийн даатгалын сангийн орлогыг 34396,6 сая төгрөгөөр буюу 97,1% хувиар биелүүлсэн. | Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг сар, улирал, жилээр жигд ханган биелүүлж, нийгмийн даатгалын санд 35,132,315.3 төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна. | Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг сар, улирал, жилээр жигд ханган биелүүллсс. 2024 оны эхний 05 сарын байдлаар нийгмийн даатгалын санд 21339,5 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, төлөвлөгөөг 157,5 хувиар биелүүлсэн. | 157,5 |
| 2.1.4. | ЭМДЕГ-аас ирүүлсэн эрүүл мэндийн даатгалын сангийн ажил олгогчийн шимтгэлийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх | | ЭМДЕГ-аас ирүүлсэн орлогын төлөвлөгөө биелсэн байна. | ЭМД-ын сангийн орлого .... төгрөг төвлөрсөн байна. | ЭМД-ын сангийн орлогын төлөвлөгөө 100 хувь биелсэн байна. | 2024 оноос эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлөх даатгуулагчдын шимтгэлийг ЭМДЕГ-т төвлөрүүлэх болсноор тус газар иргэдийн шимтгэл төлөлтийг шалгаж, мэдээлэл өгөх, шимтгэлээ цахим хэлбэрээр төлөх заавар, зөвлөгөө өгч ажиллалаа. Албан журмын даатгуулагчдын эрүүл мэндийн даатгалын шимтгэл 3305,1 сая төгрөгийн орлогыг холбогдох санд төвлөрүүлэв. | 100 |
| 2.1.5. | Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн | | Ажил олгогчоос төлөх шимтгэлийн авлагыг оны эхний дүнгээс 30- | Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн | Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн авлагыг оны эхний дүнгээс 30 хувиас | Оны эхний шимтгэлийн 9592,1 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | авлагыг бууруулах ажлыг зохион байгуулж оны эхний үлдэгдэлээс бууруулах, үр дүнг тооцож хэлтсийн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, тайланг НДЕГ-т хүргүүлэх | | аас доошгүй хувиар бууруулна. | авлага оны эхнээс 25,8 хувиар буурсан байна. | доошгүй буурсан байна. | 4472,3 сая төгрөг буюу 53,4 хувиар, шимтгэлийн өглөгийг 31,8 сая төгрөг буюу 67,9 хувиар тус тус бууруулсан байна. | |
| 2.1.6. | Сайн дурын даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийг барагдуулах | | Сайн дурын даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлийн өглөггүй гарсан байна. | Сайн дурын даатгуулагчийн шимтгэлийн тооцоог хийсэн. | Сайн дурын даатгуулагчийн шимтгэлийн тооцоог тухай бүр хийж, өглөггүй байна. | 2024 оны эхэнд 60 хүний 1204,4 мянган төгрөгийн өглөгтэй байснаас 3 хүний 816,8 мянган төгрөг буюу 67,8%-ийг барагдуулсан. Системийн шинэчлэлтэй холбоотой 6 дугаар сарын 10-ны өдрийн байдлаарх өглөгийн үлдэгдлийг харах боломжгүй байна. | 100 |
| 2.1.7. | Бусад өглөг, авлагыг барагдуулах | | Ажил олгогч, даатгуулагчийн шимтгэлийн өглөг авлагаас бусад өглөг, авлагыг хугацаанд нь барагдуулна. | Бусад өглөг авлага санхүүгийн тайлангаар баталгаажсан байна. | а)Нийгмийн даатгалын сангийн бусад өр, авлагыг оны эхний дүнгээс 50 хувиас доошгүй барагдуулах.<br>б)Нийгмийн даатгалын байгууллагын бусад өр, авлагыг бүрэн барагдуулах. | а)Нийгмийн даатгалын сангийн авлага 2023 оны жилийн эцсээр 525,1 сая төгрөг байснаас 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 524,5 сая төгрөг болж 0,6 сая төгрөг төлөгдсөн.<br>б)Засгийн газрын 2024 оны 82 дугаар тогтоолоор нийслэлийн алслагдсан 3 дүүргийн төрийн албан хаагчдад орон нутгийн нэмэгдлийг 20 хувиар тооцож олгох мөн байгууллагын бүтэц өөрчлөгдөж удирдах албан тушаалтнуудын албан тушаалын зэрэглэл өөрчлөгдсөн зэргээс үүдэн нийгмийн даатгалын шимтгэл, татварын суутгалтай холбоотой 4,1 сая төгрөгийн өр тайлант оны 05 сарын байдлаар үүсээд байна. Цалингийн | 5 |

<table>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td>судалгаа, холбогдох мэдээллийг НДЕГ-ын Бодлогын хэрэгжилт, судалгааны газарт хүргүүлсэн.<br>Үйл ажиллагааны бусад зардалд өр, авлага үүсээгүй.</td><td></td></tr>
<tr><td>2.1.8.</td><td>НДЕГ-ын даргын 2023.12.26-ны өдрийн А/183 тоот тушаалаар батлагдсан “Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх, хуваарилах, санхүүжилт олгох, хяналт тавих журам”-ын 3.3 дах заалтыг хэрэгжүүлж ажиллах</td><td></td><td>НДЕГ-ын төвлөрсөн орлогын харилцах дансанд өдөр бүр бүрэн төвлөрүүлнэ.</td><td></td><td>НДЕГ-ын төвлөрсөн орлогын харилцах дансанд өдөр бүр бүрэн төвлөрүүлсэн байна.</td><td>Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг НДЕГ-ын төвлөрсөн орлогын харилцах дансанд өдөр бүр бүрэн төвлөрүүлэн ажиллаж байна. Тайлант хугацаанд нийт 21324,4 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна.</td><td>100</td></tr>
<tr><td>2.1.9.</td><td>Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулах</td><td></td><td>Хууль тогтоомжийн дагуу иргэд даатгуулагчдад тогтоогдсон тэтгэвэр тэтгэмж төлбөр зардлыг хугацаанд нь олгоно.</td><td>Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулсан.</td><td>а)Тэтгэврийг сар бүрийн 01-ний өдөр олгох<br>б)Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төсвийн дагуу ..... төгрөгийг хуульд заасан хугацаанд зарцуулсан байна.</td><td>Тус газар нь тэтгэврийг сар бүрийн 1-ний өдөр арилжааны банкаар дамжуулан олгож хэвшсэн. 2024 оны эхний 5 сарын байдлаар нийт 5488 тэтгэвэр авагчид өссөн дүнгээр 23075,2 сая төгрөгийн тэтгэврийг олгосон. Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төсвийн дагуу хуульд заасан хугацаанд зарцуулсан байна.Үүнд
<table>
<tr><th>Сан</th><th>Төлөвлөгөө /сая/</th><th>Гүйцэтгэл /сая /</th></tr>
<tr><td>Тэтгэвэр</td><td>25622,9</td><td>25420,8</td></tr>
<tr><td>Тэтгэмж</td><td>1108,3</td><td>762,5</td></tr>
<tr><td>ҮОМШӨ</td><td>1496,1</td><td>988,9</td></tr>
</table></td><td>90</td></tr>
</table>

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Ажилгүй дэл \| 585,1 \| 479,9<br>Нийт зардал \| 28812,4 \| 23075,1 | |
| 2.1.10. | Батлагдсан зардлын төсөв, хөрөнгө оруулалтын зардлын үр ашгийг дээшлүүлж, хэмнэлтийн зарчмыг баримтлах | | Батлагдсан төсвийг зардлын эдийн засгийн ангилал хооронд шилжүүлэн зарцуулахгүй, ажиллагсадтай холбоотой болон бусад өр авлагагүй ажиллана. | Батлагдсан 619,6 сая төгрөгийн төсвөөс зардлын ангиллын дагуу 581,5 сая төгрөгийг зарцуулсан. | а)Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх.<br>б)Батлагдсан төсвийг зардлын ангиллын дагуу зарцуулах<br>в)Ажиллагсадтай холбоотой цалин, шимтгэл, татвар болон бусад өр авлага үүсгээгүй байна. | а)2024 оны 05 дугаар сарын байдлаар батлагдсан төсвийн хуваариар 333,5 сая төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагаанд 277,4 сая төгрөгийг зарцуулан 56,1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдлөг болгон ажиллаж байна.<br>б)Үйл ажиллагаанд зарцуулсан 277,4 сая төгрөгийг хөтөлбөр, арга хэмжээнд тусгасан эдийн засгийн ангиллын дагуу зарцууллаа.<br>в)Цалингийн нэмэгдэлтэй холбоотой төсвийн тодотгол хийгдээгүй тул шимтгэл, суутгалтай холбогдсон 4,1 сая төгрөгийн өрийг 06-р сард барагдуулахаар хүлээгдэж байна. | 88,9 |
| 2.1.11. | Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын сангийн болон байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөх, төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, санхүүгийн тайлан | | Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайланг үнэн зөв гаргаж, тогтоосон хугацаанд хүргүүлнэ. | Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, сангийн | Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлийн тайлан, байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, байгууллагын төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээ, сангийн өр авлагын сарын мэдээг үнэн | Нийгмийн даатгалын сангийн 1-5 сарын мэдээг үнэн зөв гаргаж, хугацаанд нь холбогдох газарт хүргүүлсэн. Санхүүгийн программын шинэчлэлтээс шалтгаалан 2024 оны 1 дүгээр улирлын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг гаргаагүй байна.<br>Өдөр тутмын гүйлгээг анхан шатны баримтыг үндэслэн төрийн сангийн удирдлагын нэгдсэн систем https://finance.gov.mn, алба хаагчдын цалин хөлсийг төрийн | 80 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | гаргах ажлыг зохион байгуулах | | | орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, байгууллагын төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээ, сангийн өр авлагын сарын мэдээг гаргаж, ирүүлсэн. | зөв гаргаж, хугацаанд нь хүргүүлсэн байна. | албаны цалингийн нэгдсэн систем https://payroll.gov.mn/ -ээр тооцож НДШ, ХХОАТ, бусад төлбөр хураамж, татвар шимтгэл, суутгалыг тухай бүр шилжүүлж холбогдох портал сайтаар тайлан гаргаж хуулийн хугацаанд хүргүүлж ажилласан. Сар бүрийн мэдээг дараа сарын 02 дотор ННДГ-т өгч, улирлын тайланг хуулийн хугацаанд нь үнэн зөв, үндэслэлтэй гаргаж удирдлагуудыг мэдээллээр ханган ажиллав. | |
| 2.1.12. | Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах өмч хөрөнгийн хэрэгцээ, захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх, ил тод тайлагнах | | Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах өмч хөрөнгийн хэрэгцээ, захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөн хэрэгжүүлж, тайлагнаж ажиллана. | Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах өмч хөрөнгийн хэрэгцээ, захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөн хэрэгжүүлж, тайлагнасан байна. | -Үндсэн хөрөнгө актлах, шилжүүлэх үйл ажиллагааг хууль дүрэм, журамд нийцүүлэн өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлт, холбогдох баримтыг үндэслэн хөрөнгийн нэмэгдэх, хасагдах хөдлөлийг цаг тухай бүрд нь бүртгэлд тусгах;<br>-Эзэмшил газар, барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, үндсэн хөрөнгө г.м/ нэгдсэн судалгааны маягтууд ТӨХ /ТӨХ-1-с ТӨХ-11 маягт/ болон мэргэжлийн байгууллагад гаргаж өгдөг мэдээ тайланг хуулийн хугацаанд мэдээлэх; | 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хүрээнд бараа материалын дансанд бүртгэлтэй үндсэн хөрөнгийн шинжтэй 9200.9 мян.төгрөгийн өртөг бүхий 27 нэр төрлийн 33 ширхэг хөрөнгийг Газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн А/04 дүгээр тушаалаар эргэлтийн бус хөрөнгөд бүртгэсэн. Зөвлөмжийн биелэлтийг аудитын байгууллагад хүргүүлсэн.<br>https://umch.sgov.mn/ төрийн өмчийн тооллогын системд 2023 оны өмчийн хөдлөл өөрчлөлтийн тайланг 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн дотор илгээсэн.<br>Хагас жилийн хөрөнгийн тооллогыг 2024 оны 06 дугаар сарын 15-20-ны хооронд хийхээр төлөвлөж бэлтгэл ажлыг ханган байна.<br>Хөрөнгийн ашиглалт | 85 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | -Хагас болон бүтэн жилийн тооллогоор үнэ тогтоолгох, шилжүүлэх, актлах, хөрөнгийн жагсаалтыг тогтоосон хугацаанд хүргүүллэх;<br>-Хөрөнгийн ашиглалт хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж, үндсэн хөрөнгө, маягтын тооллого хийх ажлыг зохион байгуулж, дүнг хугацаанд нь хүргүүлэх;<br>-Өмч хамгаалах байнгын зөвлөл журмын дагуу ажиллуулах;<br>-Үндсэн хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийн тайланг "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем" програмд дараа оны 3 дугаар сарын 5-ны дотор оруулах;<br>-Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээ, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүрэн хангах, Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээний орлогыг | хамгаалалтын хүрээнд ажлаас чөлөөлөгдсөн, албан тушаал өөрчлөгдсөн нийт 11 алба хаагчийн нэр дээр бүртгэлтэй эд хариуцагчийн картыг шинэчилсэн. Ашиглалтын явцад эвдэрсэн, хагарсан гэмтсэн хөрөнгийг тухай бүр засаж, урсгал зардалд 449,0 төгрөгийн зардал гаргасан.<br><br>НДЕГ газрын эзэмшилд байдаг Капитал банкны барилгын түрээслэгчтэй холбоотой түрээсийн төлбөр, ашиглалтын зардлын тооцоог харьяаллын дагуу манай газар хариуцаж байсан тул НДЕГ-т гаргаж өгч обьектыг PC mall-д борлуулсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | санд бүрэн төвлөрүүлсэн байна. | | |
| 2.1.13. | Төсвийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж, Аудитын байгууллагаас “Өөрчлөлтгүй” дүгнэлттэй ажиллах | | Өөрчлөлтгүй дүгнэлт авах, зөвлөмж, акт, албан шаардлагыг хугацаанд нь бүрэн биелүүлнэ. | а) Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлангийн Аудитын шалгалтаар өөрчлөлтгүй дүгнэлт авсан.<br>б) Санхүүгийн тайлангийн аудитын тайлангаар өгсөн залруулга, зөвлөмж, акт, албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна. | а)Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлангийн Аудитын шалгалтаар “Өөрчлөлтгүй” дүгнэлт авах.<br>б)Санхүүгийн тайлангийн аудитын тайлангаар өгсөн залруулга, зөвлөмж, акт, албан шаардлагыг 100.0 хувь биелүүлсэн байна. | а)2023 оны нийгмийн даатгалын санхүүгийн тайланд Эн Ай Ти Эс баланс аудит ХХК шалгалт хийж, шалгалтаар “Өөрчлөлтгүй” дүгнэлт авсан.<br>б)Аудитын шалгалтаар өгөгдсөн 2 зөвлөмж, 1 албан шаардлагын биелэлтийг хангаж, 1 актын төлбөрийг бүрэн барагдуулан биелэлтийг 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдөр аудитын байгууллагад хүргүүлсэн. | 95 |
| 2.1.14. | Нийгмийн даатгалын ерөнхий газраас банкуудтай байгуулсан ерөнхий гэрээг хэрэгжүүлэх, дүгнэх, биелэлтийг НДЕГ-т хүргүүлэх | | Нийгмийн даатгалын ерөнхий газраас арилжааны банкуудтай байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-г хэрэгжүүлэн, хэрэгжилтийг дүгнэн НДЕГ-т хүргүүлнэ. | Банкуудтай байгуулсан ерөнхий гэрээний хэрэгжилтийг хангаж ажилласан. | а)Банкуудтай байгуулсан ерөнхий гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллах.<br>б)Гэрээний хэрэгжилтийг дүгнэж, дүнг НДЕГ-т хүргүүлсэн байна. | 2023 онд арилжааны банкуудтай байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-ний хэрэгжилтийг дүгнэн 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр НДЕГ-т хүргүүлсэн. | 100 |
| 2.1.15. | Нийгмийн даатгалын сангийн цахим мэдээллийн санг тухай бүр үнэн зөв | | Холбогдох хууль тогтоомжийн дагуу мэдээллийг үнэн зөв оруулж бүртгэнэ. | Нийгмийн даатгалын сангийн мэдээллийн баазыг | а)Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг цаг хугацаанд нь үнэн зөв бүртгэх ажлыг | а)2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар банкны ажилтны алдаанаас үүдсэн 2 гүйлгээ, сангийн нягтлан бодогчийн бүртгэлийн алдаатай | **95** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бүрдүүлэх | | | тогтоосон хугацаанд хаалт хийлгэсэн. | зохион байгуулж, бүртгэлийн алдаа, залруулга гаргахгүй байх.<br>б)Ажил олгогч, даатгуулагчийн мэдээллийг үнэн зөв бүртгэж мэдээллийн сан бүрдүүлсэн байна. | холбоотой 1 гүйлгээг тухай бүр залруулсан.<br>б)Арилжааны банкаар ажил олгогч, даатгуулагчийн мэдээллийг буруу оруулсан тохиолдолд даатгуулагч болон банктай утсаар холбогдож, мэдээллийн санг үнэн зөв бүрдүүлэхэд хяналт тавин ажиллаж байна. | |
| 2.1.16. | Нийгмийн даатгалын мэдээллийн систем хөгжүүлэх" төслийн хүрээнд Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн шинэчлэлтэй холбоотой ажлыг хэрэгжүүлэх | | ХНХЯ-тай гэрээтэй Ай Ти Зон ХХК-ийн Төслийн багтай хамтран Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийг "Core" системээр хөтлөх ажлыг хийж гүйцэтгэнэ. | ХНХЯ-тай гэрээтэй Ай Ти Зон ХХК-ийн Төслийн багаас зохион байгуулсан ажлуудад оролцсон. | Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийг "Core" системээр хөтлөх ажлын гүйцэтгэлийг хангаж ажилласан байна. | Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн системийн шинэчлэлтэй холбоотойгоор Sisoc прогаммд банкнаас файл уншуулах татах, харилцагч таниулах, урьдчилж орсон орлого үүсгэх, тэтгэвэр, тэтгэмжийн хаалт хийх зэрэг ажлыг хийж гүйцэтгэж байна. | 90 |
| 2.1.17. | Нягтлан бодох бүртгэлийн тооцооны өглөг, авлагыг тооцоо нийлсэн актаар шинэчлэн баталгаажуулах | | Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулна. | Тооцооны үлдэгдлийг баталгаажуул сан. | а)Нийгмийн даатгалын байгууллагын санхүүгийн тайлангийн тооцооны үлдэгдлийг эзэн холбогдогч бүрээр бүрэн шинэчлэн баталгаажуулах.<br>б)Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлангийн тооцооны үлдэгдлийг эзэн холбогдогч бүрээр бүрэн шинэчлэн баталгаажуулсан байна. | Тус газрын 2024 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайлангаар тайлант хугацааны өглөг, авлагыг бүрэн барагдуулж, тооцоо нийлсэн акт, дансны үлдэгдлийн баталгаагаар баталгаажуулахаар хүлээгдэж байна.<br>Хамтран ажиллагч гэрээт байгууллагуудын холбогдох анхан шатны баримтыг үндэслэн гүйлгээг шилжүүлж байна. Гэрээний хугацаа дуусгавар болсон 6 байгууллагын гэрээг сунгаж, шинээр 1 хувь хүн, 1 байууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулав. | 95 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.18 | ЭМД-ийн шимтгэлээ өөрөө хариуцан төлдөг даатгуулагчтай холбоотой өглөг авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж ЭМДЕГ-т хүргүүлэхтэй холбоотой холбогдох ажлуудыг хэрэгжүүлэх | | Эрүүл мэндийн даатгалын сангийн харилцах дансуудыг хаах, харилцах дансны үлдэгдэл болон тайлангаар гарсан авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулна. | Харилцах дансны үлдэгдэл болон санхүүгийн тайлангаар баталгаажуулсан авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан. | а)ЭМД-ын харилцах дансуудыг хаах, харилцах дансны үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.<br>б) Эрүүл мэндийн даатгалын авлага, өглөгийн тайлангийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулсан байна. 3903 дансны үлдэгдлийг даатгуулагч тус бүрээр жагсаалт үйлдэж НДЕГ-т ирүүлсэн байна.<br>в) 3303 дансанд бүртгэлтэй ЭМД-ын ташаарсан орлогыг жагсаалт үйлдэж тооцоо нийлж баталгаажуулан НДЕГ-т ирүүлнэ. | а)ЭМД-ын харилцах данснуудыг 2024 оны 01 дүгээр сарыг 08-ны өдрөөр хааж, харилцах дансны үлдэгдлийг ННДГ-ын ахлах нягтлан бодогчтой тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан.<br>б) Эрүүл мэндийн даатгалын авлага, өглөгийн тайлангийн үлдэгдлийг тооцоо нийлж, 3903, 3303 дансны үлдэгдлийг даатгуулагч тус бүрээр жагсаалт үйлдэн 2024 оны 1 дүгээр сард ННДГ-ын ахлах нягтлан бодогчтой тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан. | 100 |
| Гүйцэтгэлийн дундаж хувь | | | | | | | 96 |
| **Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт** | | | | | | | |
| Нийгмийн даатгалын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, сангийн болон үйл ажиллагааны зардлын зарцуулалтад аудит хийх, дүгнэлт зөвлөмж гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх | | | | | | | |
| 3.1.1. | Байгууллагын нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтэд хяналт тавих | - | Нийтийн ил тод мэдээллийн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-8.6 дугаар заалтын дагуу 48 мэдээллийг | Байгууллагын нээлттэй мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу 48 мэдээллийг | Байгууллагын нээлттэй мэдээллийг ил тод болгож, иргэдийн мэдээлэл хайх, хүлээж авах эрхийг хангасан байна. | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-8.6 дугаар заасны дагуу шаардлагатай мэдээллийг Baganuur.ndaatgal.mn веб сайтад нийтлэв.<br>Baganuur.ndaatgal.mn сайтад оруулсан мэдээллийг | 80 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | вебсайт хуусанд бүрэн, үнэн, зөв байршуулан ажлын тайланг ДАМГ-т 2024 оны 07 дугаар сарын 09, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлнэ. | 2023 оны байдлаар 69,2 хувьтай байршуулсан. | | SHILEN.GOV.MN сайтад холбоос хаягаар байршууллаа | |
| 3.1.2. | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих | - | Нийгмийн даатгалын байгууллагын сан, үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хагас жилийн байдлаар 85 мэдээллийг 07 дугаар сарын 09-ны өдрийн дотор, жилийн эцсийн байдлаар 167 мэдээллийг Shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулан ДАМГ-т 2024 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлнэ. | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, 167 мэдээллийг 2023 оны байдлаар 96 хувьтай хугацаандаа мэдээлэл байршуулсан. | Нийгмийн даатгалын байгууллагын санхүү болон сангийн мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулж, иргэдийг үнэн, зөв мэдээллээр хангасан байна. | Мэдээллийн ил тод байдал, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж үйл ажиллагааны төсөв, зардалтай холбоотой 28 төрлийн 71 мэдээ, мэдээллийг https://info.shilendans.gov.mn/ цахим хуудаст. Байршуулсан. Хугацаа болоогүй 100 мэдээ хүлээгдэж байна. Хугацаа хоцроосон мэдээ байхгүй.<br>Мөн олон нийтэд хүртээмжтэй хүргэх зорилгоор “Ил тод, нээлттэй байдал, шилэн дансны мэдээллийн самбар”-т тухай бүр байршуулав. | 90 |
| Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг ажил олгогч, даатгуулагч, иргэн болон нийгмийн даатгалын орон нутгийн нэгжид хяналт шалгалт хийж шийдвэр гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, үр дүнг сайжруулах чиглэлээр санал боловсруулах | | | | | | | |
| 3.2.1. | Нийгмийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийг дээд газраас өгсөн чиглэлийн дагуу болон хэлтсийн | Шаардлагагүй | Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг нийт аж ахуйн нэгж байгууллагын 20 хүртэл хувьд мөн | Илэрсэн төлбөр зөрчлийн 72,6 хувийг барагдуулж ажилласан. | Шалгалтын үр дүнг тухай бүрд нь тооцон, газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж холбогдох шийдвэр гаргуулах | Гадаад болон дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөг газрын даргаар батлуулан ажиллаж байна.<br>2024 оны тайлант хугацаанд сайн дурын даатгуулагч 146 иргэнд хугацаандаа төлөөгүй шимтгэлд | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | даргын баталсан удирдамжийн дагуу аж ахуйн нэгж, байгууллага болон дотоодын хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах | | нийгмийн даатгалын 2-3 сангийн зарцуулалтад дотоодын хяналт шалгалт хийж илэрсэн төлбөр, зөрчлийн 70.0 аас доошгүй хувийг барагдуулж ажиллана. | | | ногдох 1840,3 мянган төгрөгийн алданги ногдуулж, бүрэн барагдуулаад байна.<br>Нэг тэтгэвэр авагчид дутуу олгосон 5143,0 мянган төгрөгийг олгож, нэг тэтгэвэр авагчид илүү 1413,2 мянган төгрөгийг бүрэн төлүүлсэн. 3 байгууллагын 2022, 2023 оны санхүүгийн баримтад хяналт шалгалт хийлээ.<br>Тайлант хугацаанд тус газраас ажилгүйдлийн тэтгэмж авсан 115 иргэний тэтгэмжийн хувийн хэрэг материалыг тэтгэмжийн программ болон шинэ системд нэгдсэн лавлагаатай тулган шалгалаа. Мөн жирэмсэн амаржсаны болон хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэмж нийт 1212 эмнэлгийн хуудасны бодолтыг шалган шийдвэрлэсэн байна. | |
| 3.2.2. | Хил хамгаалах ерөнхий газартай 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдөр байгуулсан 03/НД-22/23 дугаартай хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд зохион байгуулж хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг нэгтгэж дүгнэх | Шаард-лагагүй | Хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлын үр дүнг хагас, бүтэн жилээр гаргаж 2024 оны 6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-ний өдрөөр тасалбар болгон ХШГ-т тайлагнах, Илэрсэн зөрчил, дутагдлын 70 аас доошгүй хувийг барагдуулсан байх | Хил хамгаалах ерөнхий газартай хамтран ажиллах санамж бичгийг 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдөр шинэчлэн байгуулсан. | Холбогдох судалгаа, тооцоо, дүгнэлтэд үндэслэн Хилийн цэргийн анги, тусгай салбартай хамтарсан шалгалт хийж үр дүнг тооцож, цаашид авах арга хэмжээний санал боловсруулж ажиллах | Хил хамгаалах ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газрын хооронд хамтран ажиллах санамж бичгийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний хүрээнд Хилийн цэргийн 0252 дугаар ангийн албан хаагч, үйлчилгээний ажилтны ээлжийн амралтын цалинг нийт дүнгээр тайлагнасан, эмэгтэй цэргийн албан хаагч болон үйлчилгээний албан хаагчдын жирэмсний болон амаржсан хугацаа, хүүхэд асрах чөлөөтэй байсан хугацааны шимтгэл төлөлтийг тус ангиас гаргаж ирүүлсэн жагсаалтын дагуу нийгмийн даатгалын шимтгэл төлөлт, | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тайлагналын зохих хэсгүүдийг холбогдох баримтыг үндэслэн шалгаж цэргийн албан хаагч нэг эмэгтэй, энгийн албан хаагч 4 даатгуулагчийн жирэмсэн амаржсаны амралттай байсан хугацаа, хүүхэд асрах чөлөөтэй хугацааны эрүүл мэндийн даатгалын болон нийгмийн даатгалын шимтгэл нийт 349,2 мянган төгрөгийг, түүнд ногдох 174,5 төгрөгийн алдангийн хамт нөхөн төлүүлэхээр тогтоосон улсын байцаагчийн актын оны эхний үлдэгдэл нийт 523,7 мянган төгрөг төсөв шийдэгдээгүйгээс тайлант хугацаанд барагдаагүй байна. Хагас жилээр бүрэн барагдуулахыг мэдэгдсэн. Тус ангиас нийт 35 ажилтны жагсаалтыг холбогдох баримтын хамт ирүүлсэн бөгөөд түүнд цэргийн албан хаагч болон энгийн алба хаагч эхийн хүүхэд асрах чөлөөтэй, жирэмсний болон амаржсаны амралттай хугацааг орхигдуулсан гэх 9 албан хаагчаас холбогдох тушаалгүй, материалын бүрдэл хангахгүй, хуулийн зохицуулалтад хамаарахгүй нийт 4 хүний асуудлыг шийдвэрлэх боломжгүй, ээлжийн амралтын мөнгийг салгаж засварлуулах нийт 23 хүний материалаас бүрдэл хангахгүй болон материал дутуу, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон, нас барсан зэргээр хасагдаж 9 албан хаагчийн ээлжийн амралтыг бөөн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тайлагнасныг засварлахаар шийдвэрлэж, бусад 3 алба хаагчийн тушаал холбогдох баримт байхгүй тул шийдвэрлэх боломжгүй байсан болно. | |
| 3.2.3. | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн 2021-2023 оны орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт шалгалт хийх | | ҮОМШӨ-ний сангийн зарцуулалтад шалгалт хийж илэрсэн зөрчилд хуулийн дагуу хариуцлага тооцож, үр дүнг эхний хагас жилээр тайлагнаж илэрсэн зөрчлийн 80 хүртэл хувийг барагдуулж ажиллах | - | ҮОМШӨ-ний сангийн бүрдүүлэлт, зарцуулалтыг мэдээллийн нэгдсэн сангийн өгөгдөл болон анхан шатны баримтад тулгуурлан шалгаж , шийдвэрлэх | Салбарын Улсын ерөнхий байцаагчийн баталсан 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 13-07/08 дугаартай “Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын санд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу тус газарт Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газрын Нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагч Б.Хишигжаргал, Г.Бямбажаргал, О.Пүрэвжав, ахлахаар Нийгмийн хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч Г.Ганбаяр нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2024 оны 04 дүгээр сарын 08-наас 12-ны өдрүүдэд ирж ажиллалаа.<br>Шалгалтаар Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн 2021-2023 оны орлого бүрдүүлэлт, зарцуулалттай холбогдох санхүүгийн баримт материал, тус сангийн цахимжилт, тус сангаас санхүүжилт авсан аж ахуйн нэгж байгууллага, иргэд мөн өмнөх онуудад тус санд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар өгсөн, акт, албан шаардлагын биелэлт, үр дүнг шалгасан.<br>Тус сангаас 2021-2023 онд тахир | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дутуугийн болон тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгон авч буй нийт тэтгэвэр авагчдын тэтгэвэр тогтоолтын үндэслэлийг хувийн хэрэгт бүрдүүлсэн баримт материалд тулгуурлан шалгах, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэмж болон хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөрийн бодолт олголтыг үндсэн баримттай тулган шалгах, 2021-2023 онд үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас тахир дутуу болсон даатгуулагчдын тэтгэврийн даатгалын шимтгэл төлөлтийг шалгах зэргээр шалгалтад хамрагдлаа. | |
| 3.2.4. | Нийгмийн хамгааллын салбарын хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн обьектод төлөвлөгөөт шалгалт хийх | | Хяналт шалгалт хийсэн объектын тоогоор , гүйцэтгэлийн хувь, хууль сахин мөрдөлтийн түвшин, илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь, Улсын байцаагчийн шийдвэрийн биелэлт, Эрсдэлийн түвшин буурсан объектын too, хувь | - | Их, дунд эрсдэл бүхий аж ахуйн нэгж байгууллагын 80 хүртэл хувийг шалгаж, ирэлсэн зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулах | Нийгмийн хамгааллын салбарын хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн обьектын судалгааг 2-р улиралд гарган, төлөвлөгөөт шалгалт хийх ажлын төлөвлөгөөг гаргасан. Тайлант оны 3,4-р улиралд шалгалтыг удирдамжийн дагуу хийж гүйцэтгэнэ. | 50 |
| 3.2.5. | Дотоодын хяналт, шалгалтын тайланг хагас бүтэн жилээр үнэн | | Дотоодын хяналт шалгалт болон НДЕГ, хөндлөнгийн | | Шалгалтын үр дүнг хэлтсийн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж | Дотоодын хяналт шалгалтын тайланг сангийн санхүүгийн тайлантай тулган баталгаажуулж дурдсан хугацаа 2024 оны 06 | 65 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зөв гаргаж нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлантай тулган баталгаажуулах, Нийгмийн даатгалын ерөнхий газраас болон хөндлөнгийн хяналт, шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалт, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын үр дүнг тооцож тайлан, мэдээг заасан хугацаанд хүргүүлэх | | хяналт шалгалтаар илэрсэн төлбөр зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулж, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын тайланг 2024 оны 06 дугаар сарын 20, 11 дугаар сарын 20-ны өдрийн дотор ХШГ-т хүргүүлнэ. | | холбогдох шийдвэр гаргуулах | дугаар сарын 20-ны дотор гарган дээд газарт хүргүүлэхээр ажиллаж байна.<br>Дээд газрын шалгалтаар тогтоогдсон оны эхний ажилгүйдлийн тэтгэмжийн актын үлдэгдэл нэг хүний 568,4 мянган төгрөгөөс 100,0 мянган төгрөгийг барагдуулсан. | |
| Гүйцэтгэлийн дундаж хувь | | | | | | | 73,5 |
| **Дөрөв. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт** | | | | | | | |
| Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг судалж, хэрэгжилтийг хангах, төлөвлөх, тайлагнах, хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг оновчтой зохион байгуулах, нийгмийн даатгалын үйлчилгээг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах | | | | | | | |
| 4.1.1. | Нийгмийн даатгалын салбарын хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой гарсан тогтоол, тушаал шийдвэр болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд | | Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, зөвлөмж, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилт хангагдсан байна. | 2023 оны жилийн эцсийн байдлаар аймаг, нийслэлийн нийгмийн даатгалын хэлтсүүдэд НДЕГ-аас | Өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь хэрэгжүүлж, биелэлтийг 06 сарын 20, 12 сарын 20-ны дотор НДЕГ-ын | Нийгмийн даатгалын хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан түүнийг даган гарах гарах дүрэм, журам, эрх зүйн бусад баримт бичгийг Засгийн газар, холбогдох яам, агентлагаас баталж, 2024.01.01-ний өдөр буюу хууль хүчин төгөлдөр хэрэгжих хугацаанаас дагаж мөрдөхөөр зохицуулсан. | 85 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тусгагдсан арга хэмжээ, ажил үйлчилгээний хэрэгжилт, тайлан, дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь хүргүүлэх | | | өгсөн үүрэг даалгавар, тогтоол шийдвэр, чиглэл зөвлөмж, үйл ажиллагааны тайлан, зорилтот жилийн төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн авч дүгнэхэд нийт салбарын хэмжээнд хэрэгжилт 83,5%-тай хэрэгжсэн байна | Тамгын газарт хүргүүлнэ. | Шинээр батлагдсан 4 хууль, 37 эрх зүйн актыг холбогдох албан хаагчдад танилцуулж, хэрэгжилтийг 83,6 хувиар хангаж ажиллалаа. | |
| 4.1.2. | ААНБ, иргэд, даатгуулагчдаас ирүүлсэн санал, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, үр дүнг хуулийн хугацаанд тайлагнах | | Өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг хуулийн хугацаанд тайлагнасан байна. | Иргэд, байгууллагаас ирсэн санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэлт 2023 онд 100%-тай хэрэгжсэн байна. | Иргэд, даатгуулагч, ААНБ-аас ирсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд бүрэн барагдуулж, мэдээг үнэн бодит гаргаж улирал бүрийн сүүлийн сарын 20-ны дотор НДЕГ-ын Тамгын газарт хүргүүлнэ. | Нийгмийн даатгалын байгууллагаас үйлчилгээ авах хүсэлт ирүүлсэн иргэд, даатгуулагчдын хүсэлтийг өргөдөл, гомдлын дэвтэрт бүртгэж, шийдвэрлэлтэд тогтмол хяналт тавьж ажиллаж байна. 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар нийт 995 хүсэлт бүртгэгдсэнээс 80,3%-ийг шийдвэрлэж ажиллалаа.<br>Нийгмийн даатгалын цогц системийг хөгжүүлж, нэвтрүүлэх ажлыг оны эхнээс хийж хэрэгжүүлж байгаатай холбоотойгоор зарим даатгуулагчдын тэтгэвэр, тэтгэмжийг цаг хугацаанд нь тогтоох, олгох ажлууд удааширснаас үүдэн 11-11 төвд 4 | 80 |

<table>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td>гомдол бүртгэгдсэнийг тухай бүр шийдвэрлэн иргэдэд хариу мэдээлэл хүргэж, ажилласан.<br>2024 оны 1 дүгээр улирлын өргөдөл, гомдлын тайланг 2024.03.22-ны өдөр НДЕГ-т хүргүүлсэн.</td><td></td></tr>
<tr><td>4.1.3.</td><td>Нийгмийн даатгалын байгууллагын салбарын хэмжээнд архивын үйлчилгээг сайжруулах, ажил олгогч, иргэд, даатгуулагчид нийгмийн даатгалын үйлчилгээг чирэгдэлгүй, хөнгөн шуурхай үзүүлэх</td><td></td><td>Нийгмийн даатгалын хэлтэс дотооддоо болон хэлтсүүд хооронд шимтгэл төлөлтийн лавлагааг цахимаар солилцох ажлыг зохион байгуулна.</td><td>Нийгмийн даатгалын болон архивын үйлчилгээг иргэд, хуулийн этгээд, даатгуулагчдад хөнгөн шуурхай, чирэгдэлгүй үзүүлсэн.</td><td>Архивын лавлагааг цахимаар солилцох боломжийг бүрдүүлсэн байна.</td><td>2024 оны хагас жилийн байдлаар 1991-2006 оны лавлагааг метадата системээс шүүж гаргасан 199, аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газраар дамжуулан хүсэлт ирүүлсэн 47, цахим мэдээллийн сангаас 146 лавлагааг шүүж, бусад аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газраас лавлагаа авахаар явуулсан 88 хүсэлтийг уламжилж, холбогдох журамд заасан хугацаанд шийдвэрлэсэн. Тайлант хугацаанд нийт 480 хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэн иргэдэд чирэгдэлгүй үйлчилгээг үзүүлж ажилласан байна. 2023 оны мөн үетэй харьцуулан харахад 3.96%-иар өссөн үзүүлэлттэй байна.
<table>
<tr><th rowspan="2">Лавлагааны төрөл</th><th colspan="2">Огноо</th><th rowspan="2" colspan="2">Үзүүлэлт</th></tr>
<tr><th>2023 он</th><th>2024 он</th></tr>
<tr><td>Метадата</td><td>123</td><td>199</td><td>+76</td><td>+38,2%</td></tr>
<tr><td>Явуулсан</td><td>96</td><td>88</td><td>-8</td><td>-8,3</td></tr>
<tr><td>Ирсэн</td><td>42</td><td>47</td><td>+5</td><td>+10,6%</td></tr>
<tr><td>Цахим</td><td>200</td><td>146</td><td>-54</td><td>-27%</td></tr>
<tr><td>Нийт</td><td>461</td><td>480</td><td>+19</td><td>+4%</td></tr>
</table></td><td>95</td></tr>
<tr><td>4.1.4.</td><td>Батлагдсан орон тоо, төсвийн хүрээнд үйл</td><td></td><td>Төрийн албаны тухай хууль тогтоомж, журмын</td><td>Хууль тогтоомжийн хүрээнд хүний</td><td>Орон тоо, төсвийн хүрээнд хүний нөөцийг томилох,</td><td>Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн нэршил нь Нийгмийн даатгалын ерөнхий</td><td>100</td></tr>
</table>

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ажиллагаа явуулах | | дагуу хүний нөөцийг томилох, чөлөөлөх шийдвэрийг гаргаж байна. | нөөцийг бүрдүүлэх, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжоор хангах. | чөлөөлөх шийдвэрийг хууль тогтоомжийн дагуу гаргаж НДЕГ-т Тамгын газарт улирал бүр тайлагнасан байна. | хууль (шинэчилсэн найруулга)-ийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэгт зааснаар 2024.01.01-ний өдрөөс Нийгмийн даатгалын газар болж өөрчлөгдсөн. Үүнтэй холбогдуулан НДЕГ-ын даргын 2024 оны А/52 дугаар тушаалаар бүтэц, орон тоог шинэчлэн батлав. Тус газар нь тайлант оны эхний 5 сарын байдлаар батлагдсан орон тоонд багтаан ажиллаж, хүний нөөцийн 5 удаагийн шилжилт хөдөлгөөний сар бүрийн мэдээг ННДГ, НДЕГ-т товлосон хугацаанд хүргүүлсэн. | |
| 4.1.5. | Газрын дотоод ажлыг сайжруулах чиглэлээр тодорхой, шинэлэг ажил зохион байгуулах, тайланг хүргүүлэх | | Ажлын байр /албан тушаал/-ын тодорхойлолтоор заагдсан чиг үүргийг хэрэгжүүлсэн байна. | Газрын ажилтан, албан хаагчдын ажлын байрны чиг үүрэг тодорхой болсон байх. | Газрын дотоод ажлыг сайжруулсан, шинэлэг ажил үйлчилгээ нэвтрүүлсэн талаар тайланг 06 сарын 20, 12 сарын 20-ны дотор НДЕГ-ын Тамгын газарт хүргүүлнэ. | Нийгмийн даатгалын системийн хөгжүүлэлт, нэвтрүүлэлтийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор тайлант хугацаанд энэ төрлийн ажлыг хийж гүйцэтгээгүй байна. Хуулийн шинэчилсэн найруулгатай холбоотой шинэлэг 5 ажлыг тайлант оны 2 дугаар хагаст хийхээр төлөвлөсөн. | 20 |
| 4.1.6. | Нийгмийн баталгаа хангах хөтөлбөрийг дунд хугацаагаар төлөвлөн боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллах | | Газрын ажилтан албан хаагчдын нийгмийн баталгаа хангасан байна. | Ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгаа хангах дунд хугацааны хөтөлбөр боловсруулан баталж, хэрэгжүүлнэ. | Нийгмийн баталгаа хангах хөтөлбөрийг дунд хугацааны төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган, үр дүнг 06 сарын 20, 12 сарын 20-ны дотор НДЕГ-ын Тамгын газарт тайлагнасан байна. | Хэлтсийн даргын 2023 оны А/11 дүгээр тушаалаар “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа хангах хөтөлбөр”-ийг баталсан. Хөтөлбөрийн биелэлтийг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 4 дүгээр хавсралтаар баталсан загварын дагуу холбогдох газарт | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тайлагнасан. | |
| 4.1.7. | Газрын албан хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх | | Авлигаас урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулсан байна. | Газрын ажилтнуудад авлигын тухай, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулах. | Газрын албан хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэг дээшилж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана. | Авлигын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор 4 зорилт 20 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг 83,1%-иар ханган ажиллав.<br>2023 оны ХАСХОМ-ийг 5 албан хаагч 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдөрт багтаан мэдүүлж, тайланг хуулийн хугацаанд НДЕГ-т хүргүүлэв.<br>Тайлант хугацаанд албан тушаалд шилжин томилогдсон 4 албан хаагчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулах хүсэлтийг АТГ-т хүргүүлж, ирүүлсэн хариуг үндэслэн томилсон. Эдгээр албан хаагчид томилогдсоноос хойш 30 хоногт багтаан ХАСХОМ-ийг мэдүүлсэн.<br>АТГ-аас зохион байгуулсан 2 удаагийн сургалтад давхардсан тоогоор төрийн захиргааны 23 албан хаагчийг оролцуулсан бол тус газраас зохион байгуулсан 3, НДЕГ-аас зохион байгуулсан 1 удаагийн сургалтад ЭБАТ оролцож, мэдээлэл авч, түгээлээ.<br>Багануур дүүргийн хэмжээнд хэрэгжүүлэх Авлигын эсрэг үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөөнөөс тус газарт хамаарах 13 арга хэмжээний хэрэгжилтийг 81,4%-иар хангаж, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдөр дүүргийн ЗДТГ-т хүргүүлэв.<br>Тайлант хугацаанд авлига, ашиг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сонирхлын зөрчил үүсгэсэн тохиолдол гараагүй байна. | |
| 4.1.8. | Нийгмийн даатгалын газрын ажлын байрны болон үйлчилгээний стандартын хэрэгжилтийг ханган ажиллах | | НДЕГ-ын 2016.12.07-ны өдрийн “Нийгмийн даатгалын байгууллагын байцаагч (ажилтан)–ийн үйлчлүүлэгчтэй харилцах журам” батлах тухай А/61 дүгээр тушаал, 2019.12.13-ны өдрийн “Нийгмийн даатгалын хэлтэс (тасаг)–ийн ажлын байр, үйлчилгээний орчны стандарт” батлах тухай А/194 дугаар тушаалын хэрэгжилтийг мөрдөж ажилласан байна | - | Нийгмийн даатгалын газрын ажилтан албан хаагчдын харилцаа хандлагыг сайжруулж, ажлын байр, үйлчилгээний орчны стандарт хэрэгжилтийг ханган ажилласан байна. | Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 02/708 дугаар албан бичгийн дагуу тус газарт хэрэгжүүлж буй стандартын 2023 он, 2024 оны 1 дүгээр улирлын тайланг хүргүүлсэн. Уг тайлангаар Стандарт хэмжил зүйн газрын даргын 2021.07.02 С/30 дугаар тушаалаар баталсан стандарт (MNS 5140-2:2021 Баримт бичгийн бүрдэл, тэдгээрт тавигдах шаардлага, MNS 5140-3:2021 Баримт бичгийн хэвлэмэл хуудас, тэдгээрт бүрдлийг байрлуулахад тавигдах шаардлага), Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2019.12.13-ны өдрийн А/194 дүгээр тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын хэлтэс (тасаг)-ийн ажлын байр, үйлчилгээний орчны стандарт зэрэг баримт бичигт заасан стандартын хэрхэн мөрдөж байгааг тайлагнаж, холбогдох албан тушаалтнаар хяналт, шинжилгээ, үнэлгээг хийлгэн товлосон хугацаанд хүргүүлсэн. Хяналт, шинжилгээ, үнэлгээгээр тайланд тусгасан 88 үзүүлэлтийн хэрэгжилт 98,2%-иар үнэлэгдсэн. Ажилтнуудын цаг бүртгэлийн төхөөрөмжгүй, цайны болон хувцас солих зориулалтын | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өрөөгүй байгаа нь стандартад нийцэхгүй байна. | |
| Гүйцэтгэлийн дундаж хувь | | | | | | | 82,5 |
| Нийгмийн даатгалын байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, олон нийт, харилцагч байгууллага салбар хэлтэс, тасгуудад мэдээлэл түгээх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах | | | | | | | |
| 4.2.1. | Нийгмийн даатгалын байгууллагын ажилтны мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах | | Хүний нөөцийг чадавхижуулах чиглэлээр зохион байгуулсан сургалтын тоо, хамруулсан хүний тоо | Албан хаагчдыг мэргэшүүлэх, ур чадварыг дээшлүүлэх 27 удаагийн сургалтад давхардсан тоогоор 243 албан хаагчийг хамруулсан. | -Албан хаагчдыг мэргэшүүлэх, ур чадварыг дээшлүүлэх танхимын болон цахим сургалт зохион байгуулна.<br>-Шинэ ажилтныг ажлын байран дээр дадлагажуулах сургалт зохион байгуулж, хөрвөх чадвар бүхий мэргэжилтэн бэлтгэнэ. | Газрын даргын баталсан сургалтын төлөвлөгөө, ХНХЯ, НДЕГ, ННДГ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу тайлант хугацаанд Төрийн албаны зөвлөл, НДЕГ, Багануур дүүргийн ЗДТГ, бусад байгууллагаас цахим болон танхимаар зохион байгуулсан 30 удаагийн сургалтад давхардсан тоогоор 100 ажилтан, албан хаагчид оролцож, мэргэжлийн болон холбогдох бусад сэдвүүдээр мэдлэг ур чадвараа дээшлүүлсэн байна. Томоохон сургалтуудаас дурдвал:<br>-Хяналт шалгалтын тасгийн дарга Ц.Солонго нь 2024 оны 04 дүгээр сарын 08-21-ний өдрүүдэд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хотод “БНХАУ-ын Худалдааны Яам”-аас зохион байгуулсан Өвөр Монголын ХААИС-аас хэрэгжүүлсэн “Монголын нийгмийн даатгал” сэдэвт сургалтад амжилттай оролцож, сертификат авсан.<br>-НДЕГ-аас ОУ-ын хөдөлмөрийн байгууллагатай хамтын ажиллагааны хүрээнд нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлэх, байгууллагын албан хаагчдыг чадавхжуулах, шимтгэл цуглуулах ажлыг сайжруулах зорилгоор зохион байгуулсан 3 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өдрийн сургалтад Сайн дурын даатгалын байцаагч У.Урантуяа оролцож, сертификат гардан авсан.<br>-Монгол бичгийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, 2025 оноос төрийн албан хэргийг кирилл, монгол бичгээр хөтлөхтэй холбогдуулан НДЕГ, Хэлний бодлогын зөвлөл хамтран 2024 оны 06 дугаар сарын 10-наас мөн оны 07 дугаар сарын 04-ний өдрийн хугацаанд монгол бичгийн 10 удаагийн цахим сургалтыг зохион байгуулах ажлыг эхлүүлээд байна. Өнөөдрийн байдлаар зохион байгуулсан 2 удаагийн сургалтад тус газрын төрийн захиргаа, төрийн үйлчилгээний мэргэжлийн албан хаагчид идэвхтэй оролцлоо. | |
| 4.2.2. | Ажил олгогч, иргэд, малчид, албан бус хөдөлмөр эрхлэгчид, оюутан сурагчдад нийгмийн даатгалын ач холбогдол, нийгмийн даатгалын тухай хуулиудад орсон өөрчлөлт, сайн дурын даатгалын чиглэлээр сургалт зохион байгуулах | | Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх чиглэлээр зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан хүний тоо | Ажил олгогч, даатгуулагч, малчин, албан бус хөдөлмөр эрхлэгчид чиглэсэн 2 удаагийн сургалтад 47 иргэд, даатгуулагчийг хамруулсан. | Сургалт зохион байгуулж, иргэд, даатгуулагчдын нийгмийн даатгалын талаарх мэдлэг, мэдээлэл дээшилж, хамралт нэмэгдсэн байна. | Сургагч багш нар ажил олгогч байгууллагуудын дарга, захирал, нягтлан бодогч нарт зориулсан Нийгмийн даатгалын шинэчилсэн багц хууль тогтоомж, нийгмийн даатгалын шинэчилсэн цогц программ, цахим үйлчилгээний талаарх зөвлөгөө мэдээллийг хүргэх 11 удаагийн танхимын сургалт зохион байгуулж, нийт 298 байгууллага, 682 даатгуулагч, иргэдэд хүргэсэн байна.<br>Ажил олгогчдод зориулан зохион байгуулсан сургалтаар нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг шинэчилсэн цогц программаар илгээх, Нийгмийн даатгалын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шинэчилсэн багц хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд анхаарах асуудлыг тайлбарлав. Мөн нийгмийн даатгалын программ хангамж шинэчлэгдсэнтэй холбоотой ААН, байгууллагуудын нягтлан бодогч, удирдлагууд НДШ тайлан илгээх зөвлөгөө мэдээлэл авах шаардлагыг үндэслэн Орлого шимтгэлийн байцаагчийн өрөөнд ААН, байгууллагууд НД-ын шинэчилсэн программд тайлан боловсруулахад зориулан суурин компьютер байршуулж, орлого, шимтгэлийн байцаагч зөвлөгөө өгч ажиллаж байна. | |
| 4.2.3. | Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл, ач холбогдол, нийгмийн даатгалын үйлчилгээ, үйл ажиллагаа, цаг үеийн мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр өргөнөөр сурталчлах | | Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл, ач холбогдол, нийгмийн даатгалын үйлчилгээ, үйл ажиллагаа, цаг үеийн мэдээллийг сурталчлах зорилгоор орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр зохион байгуулсан арга хэмжээний тоо, төрөл, Нийгмийн сүлжээний хуудас (фэйсбүүк)-д байршуулсан мэдээллийн тоо, | Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээгээр сурталчилгаа хийсэн 62 тоо, мэдээллийн төрөл 7 | Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл, ач холбогдол, нийгмийн даатгалын үйлчилгээ, үйл ажиллагаа, цаг үеийн мэдээллийг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээ болон бусад хэлбэрээр олон нийтэд ойлгомжтой, шуурхай хүргэсэн байна. ХНХЯ болон НДЕГ-аас бэлтгэсэн мэдээллийг бүх албан хаагчдаар цааш түгээлгэж, олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулсан байна. | Тус газрын фэйсбүүк хуудасны хандалтын тоо, пэйж хуудасны дагагчийн тоо, хариу үйлдлээс иргэдийн цахим хэрэглээ жилээс жилд өсч буйг харж болох юм. 2024 оны эхний хагас жилийн байдлаар хэлтсийн фейсбүүк хуудсаар нийтэлсэн нийт 62 мэдээлэл, сурталчилгааны материал, шторконд 520 хариу үйлдэл, 144 хуваалцал, 30042 хандалттай байна. Багануур дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс фейсбүүк хуудас нь 2023 оны 12 дугээр сарын 31-ний өдөр 3800 дагагчтай байсан бол 2024 оны 06 дугаар сарын 13-ны өдөр 4013 дагагчтай болсон байна. Фэйсбүүк хуудасны мессенжер чатаар иргэд, даатгуулагчидтай байнга харилцаж, иргэдийн цаг зав, зардал мөнгийг хэмнэж, ажлыг хөнгөвчилж үйлчилгээг | 95 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хандалтын тоо. Бэлтгэсэн нэвтрүүлэг, видео шторк, контент, цахим хичээл, постерын тоо. Иргэд, даатгуулагчид, ажил олгогчид, зорилтот бүлгүүд буюу хувиараа хөдөлмөр эрхлэгчид, малчдад чиглэсэн сурталчилгааны тоо, төрөл зохион байгуулсан арга хэмжээний тоо, төрөл | | | түргэн шуурхай хүргэж байна. Мөн хэлтсийн фэйсбүүк хуудсаар дамжуулан ажил олгогч байгууллагуудын дарга, захирал, нягтлан бодогч нарт сургалтын мэдээлэл постер хэлбэрээр хүргэсэн нь үр дүнтэй байлаа. Цахимаар түгээсэн зарын дагуу ажил олгогчид товлосон цагтаа цахим сургалтад идэвхтэй оролцсон. | |
| Нийгмийн даатгалын харилцаанд оролцогч талуудад эмнэлэг хөдөлмөрийн магадлалын чиглэлээр мэргэжил арга зүйн үйлчилгээ үзүүлэх | | | | | | | |
| 4.3.1. | Эрүүл мэндийн магадлалын талаарх хууль тогтоомжийн биелэлтийг хангаж ажиллах | | Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа шалтгаан шийдвэрлүүлж буй иргэдийн оношийн баталгаажилтад жилд 4-өөс доошгүй удаа хяналт хийсэн байна. | Зохион байгуулсан ажлын тоо, тайланг ЭММТЗ-д хүргүүлсэн байна. | Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа шалтгаан шийдвэрлүүлж буй иргэдийн оношийн баталгаажилтад хяналт хийж холбогдох арга хэмжээ авсан байна. | Тус газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн хурал 7 хоног бүрийн Пүрэв гарагийн 15:00 цагт, Нийгмийн эрүүл мэндийг дэмжих төвд 80-100% ирцтэйгээр нийт 18 удаа хуралдаж, өвчтөний бичиг баримтад үндэслэн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, хэмжээг 45 иргэнд шинээр тогтоож, 20 иргэний ХЧА-ын хувь хэмжээг цуцалж, 182 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг сунгаж шийдвэрлэсэн. ЭММЗ-ийн мэдээллийн санд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа, хэмжээг тогтоолгосон 886 иргэн бүртгэлтэй байна. Хөдөлмөрийн | 95 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | чадвар алдалтын хувь хугацаа, шалтгааныг магадлах, хөдөлмөр зохицуулалт хийхэд баримтлах өвчний шинээр батлагдсан жагсаалтыг хэрэгжүүлэн ажиллахад өмнөх хувь буурсан 16, хувь өссөн 25 иргэн байна.<br>Шинээр хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацаа, шалтгааныг тогтоолгож буй иргэний оношийг магадлах, биеийн байдлыг үнэлэх, мэдээлэл солилцох, эмчлэн эрүүлжих зөвлөгөө өгөх, цаашид зөв чиглүүлэх зэрэг асуудлаар хуралд иргэнийг өөрийг нь байлгах шаардлагатай тул хүнийг хуралд биечлэн оролцуулж шийдвэрлэж байна. | |
| | | | Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн мэдээллийн цахим сангийн бүрдүүлэлтэд хагас жил тутам тулгалт хийсэн байна. | | Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн мэдээллийн цахим сангийн бүрдүүлэлтэд жилд 2 –оос доошгүй удаа тулгалт хийж зөрчил дутагдлыг тухай бүр арилгах арга хэмжээ авч ажилласан байна. | Мэдээллийн сангийн бүрдүүлэлтийн хяналтыг улирал тутам тулган зөрүү гарахаас урьдчилан сэргийлж, нийгмийн даатгал, нийгмийн халамж, зөвлөлийн мэдээлэл, хорих ангийн тэтгэвэр авагчдын мэдээллийг тулган хянаж ажилладаг.<br>Хагас жилийн хяналтаар 910 иргэний мэдээлэлд тулгалт хийж хянахад нас барсан 1, шилжсэн 2, шимтгэл төлсөн хугацааг үндэслэн 3 хүний мэдээлэлд хөдөлгөөн хийж зөрүүг арилгалаа. | 100 |
| 4.3.2. | Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагааны чанар хүртээмжийг сайжруулах арга | | Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагаанд тавих дотоод хяналт, | Зохион байгуулсан ажлын тоо, тайланг ЭММТЗ-д | Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагаанд тавих дотоод хяналт, шалгалтыг зохион | ЭММЗ-ийн шинэчлэгдсэн журмын дагуу иргэнийг хуралд биеэр ирүүлэхгүй хөдөлмөрийн чадвар алдалтын шийдвэрийг гаргах чиглэлийг хэрэгжүүлэн ажиллав. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэмжээ зохион байгуулсан байх | | шалгалтыг хагас жил тутам зохион байгуулж, үр дүнг тооцсон байна. | хүргүүлсэн байна. | байгуулж, үр дүнг тооцсон байна. | Зарим тохиолдолд хурлаар танилцуулагдаж буй өвчтөний холбогдох бичиг баримт, оношийн баталгаажилтыг давхар магадлан хянаж, эмчлэн эрүүлжүүлэх төлөвлөгөөг ярилцаж, төлөвлөн, мэдээлэл солилцож, өвчтөнийг цаашид зөв чиглүүлэх талаар чиглэл өгч, дотоодын хяналтыг тасралтгүй явуулдаг бөгөөд үүний үр дүнд дүүргийн хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн тоо тогтмол буурч байна. Дүүргийн нийт хүн ам /29342/-ын 3 хувийг /886 ХБ иргэн/ эзэлж байна. | |
| | | | Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагаанд оролцогчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, ижил мэргэжилтний үзлэгийг 2-оос доошгүй удаа зохион байгуулсан байна. | | Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагаанд тавих дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулж, үр дүнг тооцсон байна. | ЭММТЗ-с удирдамж гарган 3 аймаг, нийслэлийн дүүргүүдийн ЭММЗ-н тус бүр эмчийг хамруулан өвчтөний амбулаторийн картанд 2024.06.14 өдөр цахимаар ижил мэргэжилтний үзлэгийг зохион байгуулж байна. Тус дүүргээс 1 өвчтөний мэдрэлийн амбулаторийн картыг цахимжуулан хүргүүлсэн. | 100 |
| 4.3.3. | Эрүүл мэндийн магадлалын оролцогч талуудын үйл ажиллагааг нэгтгэн хэрэгжилтийг хангаж ажиллах | | Хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэх, бууруулах жилийн төлөвлөгөө гарган, хэрэгжүүлэн ажиллана. | Төлөвлөгөөний хэрэгжилтийн болон судалгааны тайланг ЭММТЗ-д хүргүүлнэ. | Хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэх, бууруулах төлөвлөгөө гарган, хэрэгжүүлсэн байна. | Хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлж, бууруулах зорилгоор хурлаар орж буй эмчийн амбулаторийн картанд ижил мэргэжилтний үзлэг хийж оношийн баталгаажилтыг хянан магадалж, тухайн өвчтөнийг эмчлэн эрүүлжүүлэх төлөвлөгөөний санал, мэдээлэл солилцож арга зүйн зөвлөгөөг өгч ажилладаг.<br>Зөвлөлийн гишүүд өөр өөрийн үүрэгтэй ажилладаг бөгөөд | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өвчтөний хяналтын карт хөтлөлт, амбулаторийн картанд эмчлэн эрүүлжих төлөвлөгөөг бичсэн эсэх хяналтыг мэдрэлийн төрөлжсөн мэргэжлийн эмч, эмнэлгийн хувийн хэргийн бүрдэл, бичилтийг мэс заслын төрөлжсөн мэргэжлийн эмч, өвчтөний амбулаторийн картанд хөдөлмөрийн чадвар алдалтын шийдвэрийн наалт, бичилтийг дотрын төрөлжсөн мэргэжлийн эмч, өвчтөнд хөгжлийн бэрхшээлтэй иргэний хууль, эрх зүй, журмын мэдээлэл өгч, мэдээллийн сангийн үнэн зөв байдал, өвчтөний бичиг баримтад хяналт тавьж, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, заалт, оношийг бодитой зөв гаргах зэргийг магадлан, хурлын үйл ажиллагааг тасралтгүй явуулах, уялдаа холбоог ханган ажиллалаа. | |
| | | | Орон нутгийн иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалтын байдалд суурь болон харьцуулсан судалгаа хийж, тодорхой арга хэмжээ авч орон нутгийн удирдлага, холбогдох байгууллагад танилцуулсан байна. | | Орон нутгийн иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалтын байдалд суурь болон харьцуулсан судалгааг хийж дүгнэсэн байна. | Тус дүүргийн иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон иргэдийн тоог дүүргийн нийт хүн амын тоотой /29342/ харьцуулбал 2015 онд 3,67 байсан боловч жил бүр тогтмол дүнгээр буурч, 2023 оны жилийн эцсээр хүн амын 2,9 хувийг эзэлж байна.<br>Сэтгэцийн эмгэг, дотрын өвчин, мэдрэлийн эмгэг, сонсгол тэнцвэрийн эрхтний эмгэг, нүд, гэмтлийн эмгэгүүд хөдөлмөрийн чадвар алдалтын 90 гаруй хувийг эзэлж байна. Хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн 70 гаруй | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хувь нь ажилгүй, 31-59 насны хөдөлмөрийн насны 78% иргэн байна. Хагас бүтэн жилээр тоон тайланг гарган холбогдох удирдлагуудад танилцлаа. | |
| 4.3.4. | Эрүүл мэндийн магадлалын талаарх хууль тогтоомжийн талаар болон авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулах | | Төрөлжсөн мэргэшлийн болон сум, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтнүүдэд эрүүл мэндийн магадлалтай холбоотой хууль тогтоомжийн талаар болон авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр жилд 2-оос доошгүй удаа сургалт зохион байгуулсан байна. | Зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан хүний тоо, тайланг хүргүүлсэн байна. | Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн болон төрөлжсөн мэргэшлийн, сум, өрхийн Эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтнүүдэд эрүүл мэндийн магадлалтай холбоотой хууль тогтоомжийн талаар сургалт зохион байгуулж шинэ мэдээ, мэдээллийг хүргүүлж ажилласан байна. | Эрүүл мэндийн магадлалтай холбоотой тушаал шийдвэрийг тухай бүр холбогдох эмч, мэргэжилтнүүдэд танилцуулж, хэрэгжилтийг ханган хамтарч ажилладаг.<br>ЭММТЗ-с АТГ-тай хамтран 2024.05.24-ний өдөр ЭММЗ-н гишүүдэд цахимаар зохион байгуулсан сургалтад гишүүд 100% хамрагдсан бөгөөд хурлаар орж буй өвчтөн зөвлөлийн гишүүнтэй ашиг сонирхлын зөрчил үүсэх тохиолдол бүрд хурлын гишүүнээр тусгай маягт бөглүүлэн зөвлөлийн даргад танилцуулан журмын дагуу ажиллаж хэвшсэн. | 100 |
| Нийгмийн даатгалын үйлчилгээг мэдээллийн технологийн үйл ажиллагаагаар дэмжих, мэдээллийн сан бүрдүүлэлт, хадгалалт хамгаалалт, гадаад, дотоод мэдээллийн урсгалын нэгдсэн хяналттай тогтолцоог төлөвшүүлэх, хөгжүүлэх | | | | | | | |
| 4.4.1. | Мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг сайжруулж, ажил олгогчоос ирүүлэх мэдээллийг бүрэн гүйцэд бүрдүүлсэн байх | | Ажил олгогчийн үндсэн мэдээллийг бүрэн гүйцэд бүрдүүлсэн байх | Ажил олгогчийн үндсэн мэдээллийн бүрдүүлэлт 99.94% байсан. | Ажил олгогчийн ЭЗҮАСА, татварын бүртгэлийн дугаарыг бүрэн бүрдүүлсэн байна. | Sicos системд шинээр нийт 17 ажил олгогч байгууллагын мэдээллийг бүртгэхэд үндсэн мэдээлэл, ЭЗҮАСА, өмчийн болон хариуцлагын хэлбэр зэрэг нь улсын бүртгэлийн мэдээллийн сангаас автомаар татагдсныг тулган шалгаж, цахим системд хэрхэн нэвтрэх заавар зөвлөгөөг өгөв. | 80 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Ажил олгогчийн НДШ-ийн тайланд ирүүлэх даатгуулагчийн мэдээллийг бүрэн, зөв бүрдүүлсэн байх | | -Даатгуулагчийн үндсэн мэдээллийг бүрэн, зөв хүлээн авсан байна.<br>-Даатгуулагчийн төрлийг бүрэн, зөв хүлээн авсан байна.<br>-Даатгуулагчийн улсын кодыг бүрэн, зөв хүлээн авсан байна.<br>- Даатгуулагчийн ажил мэргэжлийн ангиллыг бүрэн, зөв хүлээн авсан байна. | Даатгуулагчийн үндсэн мэдээллийг улсын бүртгэлийн мэдээлэлтэй тулган илэрсэн зөрчлийг арилгуулж, үндсэн мэдээллийг зөв хүлээн авч ажиллаж хэвшсэн.<br>Тайланд тусгагдсан даатгуулагчдын мэдээллийн үндэслэлийг шалгахдаа даатгуулагч бүрийн төрлийн кодыг нэгдсэн мэдээллийн сангаас /ndlav/-аас нягталж, зөрүүтэй мэдээллийг ажил олгогчийн нягтлан бодогчоор засварлуулан, даатгуулагчийн төрлийг үнэн зөв илэрхийлэгдсэн тайланг авч, даатгуулагчийн улсын кодыг зөв хүлээн авч, даатгуулагчийг давхардуулан бүртгэсэн эсэхэд хяналт тавин ажиллаж байна. | 90 |
| 4.4.2. | Албан журмын болон сайн дурын даатгуулагчийн ногдуулалтын мэдээллийг үнэн зөв бүртгэсэн байх | | Албан журмын болон сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгэхгүй байх | Ажил олгогчийн үндсэн мэдээллийн бүрдүүлэлт 99.94% байсан. | Албан журмын болон сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгэхгүй байна. | НДЕГ-ын даргын А/190 дүгээр тушаалаар “Нийгмийн даатгалын шимтгэл төлөгчид бүртгэлийн дугаар олгох, хэрэглэх болон хувийн хэрэг нээх бүртгэх, хөтлөх, шилжүүлэх журам”-ыг баталсан. Уг журмын дагуу хувийн хэрэг нээж, ХНХСайдын 2023 оны А/199 дүгээр тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах, шимтгэлийг нөхөн төлүүлэх журам”-ыг үндэслэн ажил олгогчоос цахимаар тайлан ирүүлэх үед ажлаас гарсан, ажилд шинээр орсон ажилчдын хөдөлгөөнийг шалган тодруулж, даатгуулагчийн томилогдсон, чөлөөлөгдсөн тухай тушаалын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бүртгэлийг тухай бүр оруулж байхыг шаардлага тавин ажиллаж байна<br>Албан журмын болон сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгэхгүй ажилласан байна. | |
| | | | Сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгэхгүй байх | | Сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгэхгүй байна. | 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар 1162 даатгуулагчийн гэрээг давхардалгүй бүртгэсэн байна. | 100 |
| | | | Сайн дурын даатгуулагчийн ногдуулалтыг төлөлтөөс хэтрүүлж хийхгүй байх | | Сайн дурын даатгуулагчийн ногдуулалтыг төлөлтөөс хэтрүүлж хийхгүй байна. | Сайн дурын даатгуулагчийн гэрээг Sicos системд бүртгэн гэрээний хуваарийн дагуу ногдуулалтыг тухай бүр хийж байна. | 90 |
| 4.4.3. | Мэдээллийн технологийн ашиглалтыг сайжруулах | | Програм хангамжуудыг зөв зохистой ашиглаж, аюулгүй байдлыг хангах | | Програм хангамжуудын эрхийн тохиргоог зөв хийх, байцаагч ажилтнууд програм хангамжуудыг зөв зохистой ашиглаж, аюулгүй байдлыг хангаж ажилласан байна. | Нийгмийн даатгалын программ ханмгамж шинчлэгдсэнтэй холбоотой байцаагч, албан хаагчдын хандах эрхийн тохиргоог https://keycloak.ndaatgal.mn/ дээр олгон ажиллаж байна. | 100 |
| | | | МТТ-өөс хүргүүлсэн албан бичгийн хариу, судалгааг цаг хугацаанд нь ирүүлэх, бусад үүрэг болгосон ажлыг хэрэгжүүлсэн байх | | МТТ-өөс зохион байгуулсан ажлын гүйцэтгэл, албан бичгийн хариу, судалгааг цаг хугацаанд нь үнэн зөв бүрэн ирүүлсэн байна. | НДЕГ-ын МТТ-ийн захирлын 2023 оны А/33 дугаар тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын байгууллагуудын хэрэглэгчийн болон сервер компьютерийн ашиглалт, тэдгээрт хандах хэрэглэгчийн эрх, нууцлал хамгаалалт, аюулгүй байдлын журам”-ыг нийт албан хаагчдад танилцах хуудсаар танилцуулав. Журмын хүрээнд компьютерийн | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | аюулгүй ажиллагааг ханган албан хаагчдад и-мэйл хаяг ашиглах талаар мэдээлэл зөвлөмж хүргэж, ажлаас чөлөөлөгдсөн 2 албан хаагчийн хандах эрхүүдийг цуцлах, ажилд томилогдсон 2 албан хаагчид холбогдох эрх нээлгэх хүсэлтийг НДЕГ-ын дэргэдэх МТТ-д хүргүүлж, шийдвэрлүүлсэн.<br>МТТ-өөс ирүүлсэн хариутай албан бичигт товлосон хугацаанд хариу хүргүүлж ажиллав. | |
| Гүйцэтгэлийн дундаж хувь: | | | | | | | 96,1 |
| Гүйцэтгэлийн нийт дундаж хувь: | | | | | | | 88,2. |

ТАЙЛАН ХЯНАСАН:
НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА Л.МӨНХЗУЛ

......... оны ...... дугаар сарын ......

ТАЙЛАГНАСАН:
БАГАНУУР ДҮҮРГИЙН НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГА Р.ӨНӨРЖАРГАЛ

2024 оны 06 дугаар сарын 14

9103536
2724010001
АМТ05776